



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын хороодыг хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит зургаадугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Хурлын хороодыг хуралдуулсугай.

2. Хурлын хороодын хуралдааны удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Хороодын хуралдаанаас гарсан санал, дүгнэлтийг Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит 12 дугаар хуралдаанд танилцуулахыг Хурлын хороодын дарга нарт даалгасугай.

4. Хурлын хороодын хуралдааны бэлтгэл ажил, техник зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/, дүүргийн Засаг даргын Тамгын газар /Ж.Эрдэнэбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 сарын
28-ны өдрийн 60 дугаар тогтоолын хавсралт



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын хороодын ажиллах удирдамж

Нэг. Хурлын хороод нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит зургаадугаар хуралдаанаар хэлэлцэгдэх дараах асуудлуудыг урьдчилан бэлтгэж, санал дүгнэлт боловсруулна. Үүнд:

1. Дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэл
2. Дүүргийн 2014 оны төсөвт өөрчлөлт оруулах, 2015 оны төсвийн төсөл
3. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийн 2014 оны зорилтын хэрэгжилт, 2015 оны зорилтын төсөл
4. Дүүргийн 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2015 оны төлөвлөгөөний төсөл

Хоёр. Хурлын хороод танилцсан ажлын чиглэлээр гаргасан саналаа Хурлын Ажлын албанд ирүүлнэ. Засаг даргын Тамгын газар хороодоос ирүүлсэн саналуудыг төсөлд тусгасан эсэх талаар Хурлын хороодод тухай бүрт нь албан бичгээр хүргүүлж ажиллана.

Гурав. Хурлын хороод хэлэлцсэн асуудлаар дүгнэлт боловсруулан 2014 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан, 2014 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит зургаадугаар хуралдаанд тус тус танилцуулна.

Дөрөв. Хурлын хороод ажиллахад шаардагдах зардлыг /тээвэр, шатахуун, баримт материал олшруулах, хэвлэх/ Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.

Тав. Хороодын ажиллах хуваарь:

№	Хурлын хороод	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцсан хорооны дарга, нарийн бичиг	Хариуцсан хэлтэс, алба
1	Нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн хороо	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2014 оны зорилтын хэрэгжилт,	2014.12.03 09 ⁰⁰	Ү.Тэгшбаатар Б.Гүжин	ЗД-ын орлогч Ж.Лхагвасүрэн ТГ Ж.Эрдэнэбат ЗХХ Б.Мөнгөнсүх НХ Э.Энхжаргал
2	Иргэний оролцоо,	2015 оны нийгэм, эдийн засгийн	2014.12.03 14 ⁰⁰	Ч.Болормаа Ч.Энхчимэг	ТГ Ж.Эрдэнэбат

	санал хүсэлтийн хороо	зорилтын төсөл /харъяалах асуудлаар/			ИОХ Т.Уламбаяр ЗХХ Б.Мөнгөнсүх
3	Дэд бүтэц, тохижилт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн асуудал эрхэлсэн хороо		2014.12.04 09 ⁰⁰	Д.Алтанхуяг Н.Янжинлхам	ЗД-ын орлогч Ц.Содхүү ТГ Ж.Эрдэнэбат ДБТХ А.Гэрэлт-Од ХҮХ Д.Булган
4	Эрх зүй, Төрийн байгууллагын асуудал эрхэлсэн хороо		2014.12.05 09 ⁰⁰	Ц.Рэнцэндорж Г.Сэлэнгэ	ТГ Ж.Эрдэнэбат ЗХХ Б.Мөнгөнсүх ЭЗТХ Л.Норов
5	Байгаль орчин, экологийн асуудал эрхэлсэн хороо	Дүүргийн 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл	2014.12.05 14 ⁰⁰	Л.Давийчомбо Б.Өнөрбат	ЗД-ын орлогч Б.Батхуяг ТГ Ж.Эрдэнэбат ДБТХ А.Гэрэлт-Од ӨГХА М.Алтансүх
6	Төсвийн зарцуулалтын хяналтын асуудал эрхэлсэн хороо	Дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэл	2014.12.09 09 ⁰⁰	Б.Батбаатар Ц.Хонгор	ЗД-ын орлогч Б.Мөнхбат ТГ Ж.Эрдэнэбат СТСХ Ж.Орхонбаяр ЭЗТХ Л.Норов
7	Эдийн засаг, Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн хороо	Дүүргийн 2014 оны төсөвт өөрчлөлт оруулах, 2015 оны төсвийн төсөл /өргөтгөсөн хэлбэрээр/	2014.12.10 09 ⁰⁰	Л.Баярсайхан Э.Анхтуяа	ЗД-ын орлогч Б.Мөнхбат ТГ Ж.Эрдэнэбат СТСХ Ж.Орхонбаяр ЭЗТХ Л.Норов

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит зургаадугаар хуралдаан хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит зургаадугаар хуралдааныг 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09⁰⁰ цагт дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцэхээр тогтсугай.

Үүнд:

- 1) Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийн 2014 оны зорилтын хэрэгжилтийг дүгнэж, 2015 оны зорилт батлах тухай /Илтгэгч нь: Дүүргийн Засаг дарга Д.Ганболд/
- 2) Дүүргийн 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай /Илтгэгч нь: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Орхонбаяр/
- 3) Дүүргийн 2014 оны төсөвт өөрчлөлт оруулах, 2015 оны төсөв батлах тухай /Илтгэгч нь: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Орхонбаяр/
- 4) Дүүргийн 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, 2015 оны төлөвлөгөө батлах тухай /Илтгэгч нь: Дүүргийн өмч, газрын харилцааны албаны дарга М.Алтансүх/
- 5) Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн 2014 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга. /Илтгэгч нь: Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Ц.Алтанцацрал/

2. Хуралдаанд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

3. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/, дүүргийн Засаг даргын Тамгын газар /Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Шагнах тухай

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журам”-ыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрхэлсэн ажилдаа амжилт гарган дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан Чингэлтэй дүүргийн харъяат иргэд, төрийн албан хаагчдыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнахаар шийдвэрлэсүгэй.
2. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 сарын
28-ны өдрийн 62 дугаар тогтоолын хавсралт



Шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1	З.Гульдарига	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны Улсын бүртгэгч	УЕ77092006
2	С.Сайнзаяа	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны Хэсгийн ахлагч	КЮ80040902
3	Б.Нарандолгор	Чингэлтэй дүүргийн нийгэм халамж үйлчилгээний хэлтсийн 18 дугаар хороо хариуцсан мэргэжилтэн	ХЕ81100901
4	С.Ганчимэг	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны Хэсгийн ахлагч	ВН73070101
5	Г.Үржинханд	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны ахмад настан	ХМ49070105
6	М.Пүрэвдорж	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны өрхийн их эмч	ХМ49050214
7	Л.Баярмаа	Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч	ИГ71050102
8	Ж.Төрмөнх	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч	ЦД84050377
9	Л.Батцэцэг	Чингэлтэй дүүргийн 37 дугаар цэцэрлэгийн нярав	ИХ74120608
10	С.Оюунчимэг	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны Шэжид дүг өрхийн эмнэлэгийн Ня-бо	ЦА64012062
11	Г.Оюунгэрэл	Чингэлтэй дүүргийн 102 дугаар цэцэрлэгийн нярав	Ш359042781
12	С.Мөнхзул	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн нярав	ЙГ86051001
13	Ж.Нэргүй	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн	ЧМ60102295
14	Н.Дагиймаа	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн	ИЖ77010204
15	Ц.Энхбат	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн, мужаан	НЮ62092919
16	Д.Дуламханд	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны ахмад настан	УК59123006
17	Т.Саранчимэг	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн, Баянбулаг ХХК-ны үйлчлэгч	АР67070104
18	Т.Адъяатөмөр	Голден жим фитнес клубын багш дасгалжуулагч	ТЯ90103150
19	Б.Халиунаа	Голден жим фитнес клубын багш дасгалжуулагч	УЧ90111923



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

“СҮХБААТАРЫН ОДОН”-ООР:

- | | |
|---------------------|---|
| 1. Янжингийн Шархүү | Барилга, хот байгуулалтын зураг төслийн “Арт-констракшн” ХХК-ий Зөвлөх архитектор |
|---------------------|---|

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ООР:

- | | |
|---------------------------|--|
| 1. Пүрэвжавын Тунгалаг | Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны Боловсролын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан |
| 2. Доржсүрэнгийн Гэрэлмаа | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны иргэн, Элма Хужирт рашаан сувиллын Захирал |
| 3. Авирмэдийн Батзориг | “Олон нийтийн хяналт” ТББ-ын Тэргүүн |

“АЛТАН ГАДАС ОДОН”-ООР:

- | | |
|---------------------------|---|
| 1. Мижиддоржийн Байгалмаа | “Форум-Арт” ХХК-ий Зөвлөх архитектор |
| 2. Пунцагийн Намбар | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны Ахмад настан |
| 3. Сүрэнжавын Дамдин | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны Ахмад настан |

- | | |
|-----------------------------|--|
| 4. Дэчинхүүгийн Ядмаа | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны
Ахмад настан |
| 5. Дамдингийн Төгсөө | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны
Ахмад настан |
| 6. Эршүүгийн Орхон | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны
Засаг дарга |
| 7. Дэшигжавын Шүрэнцэцэг | Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх
Татварын хэлтсийн Татварын улсын
байцаагч |
| 8. Дугарсүрэнгийн Нансалмаа | Чингэлтэй дүүргийн 117 дугаар сургуулийн
Түүхийн багш |

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛ”-ИАР:

- | | |
|-------------------------|--|
| 1. Цэвээний Цэцэнбилэг | Шинжлэх ухааны академийн Философи,
социологи, эрхийн хүрээлэнгийн
Социологийн салбарын эрхлэгч |
| 2. Дашцэрэнгийн Баянбат | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны
Иргэдийн Нийтийн Хурлын дарга |

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Дүүргийн 2014-2016 оны “Хүний нөөцийн
хөгжил” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Хүний нөөцийн хөгжил” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн үр дүнг жил бүрийн 3 дугаар улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ



Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Ерөнхийлөгчийн “Том төрөөс Ухаалаг төр рүү” санаачлага, “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөр, дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн төрийн албаны бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээг цомхон, мэдлэг чадвартай, өөрчлөлтөд зохицож чаддаг ажилтнуудын тусламжтайгаар үзүүлэх шаардлага урган гарч байна.

Иргэдийн ойр, хэрэгцээ шаардлагыг нь хангасан, чанартай үйлчилгээг үзүүлэх үүднээс Дүүргийн төрийн байгууллагуудад чадварлаг ажилтныг авах, тэдгээрийг бэлтгэх, ур чадварыг төлөвшүүлэх, ажилтнуудын авъяас чадварыг хөгжүүлэх шаардлагатай болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Байгууллагын өөрийн өөрчлөлт, хөгжлийн бодлогоор тавигдсан зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд тоо, чанарын шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх, нөөцийг аль болох үр ашигтай зохион байгуулах зорилгоор тодорхой, дэс дараалсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

Байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтод үндэслэн байгууллагын бүтэц, хүний нөөцийн хөгжлийн бодлого нь төлөвлөгдөнө.

Албан хаагчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ирээдүйд шаардагдах ажилтны орон тоо, ур чадвар, мэдлэг чадвар ба зардлыг тусгасан байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлдэг болно.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт:

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн үндсэн зорилго нь Чингэлтэй дүүргийн төрийн байгууллагын зорилтын хүрээнд хүний нөөцийг сургах, хөгжүүлэх, хуваарилах, мэргэшсэн албан хаагчдыг сонгох болон тэдний мэргэжлийг дээшлүүлэх асуудлыг шийдвэрлэж чадварлаг мэргэшсэн хүний нөөц бүхий байгууллагууд бий болох дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хөтөлбөрөөр дэвшүүлж буй зорилтууд:

1. Дүүргийн төрийн үйлчилгээний чанар, стандартыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, зохицуулалтаар хангах
2. Дүүргийн нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн оновчтой бодлого, зохицуулалтаар хангах
3. Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах

4. Төрийн байгууллагын хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох

5. Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдлыг хангах

Дөрөв. Төрийн байгууллагын хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох бодлого:

Хүний нөөцийн менежментийн гол зорилтуудын нэг болох хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд байгууллагын бүх шатны албан хаагчид хүний нөөцийн болон байгууллагын бодлого, төлөвлөлтийг боловсруулахад оролцдог, хариуцлагыг мөн хуваалцдаг байна.

Төрийн болон төсөвт байгууллага нь харьяа дээд байгууллагаас нь баталсан бүтэц, орон тоогоор ажиллах буюу хэрэв зөвхөн орон тооны дээд хязгаарыг тогтоож өгсөн тохиолдолд түүнд таарсан бүтцийг баталж мөрдөнө.

Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан тушаалын чиг үүргийн хуваарилалтын байдал, ажлын давхардал, хийдэл байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, ажлын байрны тодорхойлолт шинээр боловсруулах үүрэг бүхий байнгын, орон тооны бус ажлын хэсгийг Дүүргийн Засаг даргын Тамгын газарт байгуулж ажиллуулна.

Цаг үеийн өөрчлөлт, шинэ техник, технологийн хөгжил, дэвшил, эрх зүйн орчны шинэчлэлт зэргийг мэдэрч үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, албан тушаалын чиг үүрэгтээ тусгах талаар хамт олны саналыг үндэслэсэн уян хатан бодлого барина.

Байгууллага бүр хүний нөөцийн хэрэгцээгээ урьдчилан төлөвлөж, уг төлөвлөгөөндөө тэтгэвэрт гарах, жирэмсний болон амаржсаны амралт, эмчилгээ сувилгаанд явуулах, сургууль, курст суралцах, ажлаас чөлөөлөгдөх, тушаал дэвших, буурах, өөр ажилд шилжих зэрэг хөдөлгөөн, өөрчлөлтийг тусгана.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу ажиллана.

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх, нөөцийн сан бүрдүүлэх, нөөцийн сангаас албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхтэй холбогдсон харилцааг Төрийн албаны зөвлөлөөс баталсан журмын дагуу Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл зохион байгуулна.

Төрийн байгууллагын хүний нөөцийн нэгж, ажилтнууд ажиллагсдынхаа дадлага чадвар, хүсэл сонирхол, ажлын хэрэгцээг тооцсон судалгаа, мэдээлэлтэй байх. Энэ нь байгууллагын ажлын бүтээмжид нөлөөлөх гол хүчин зүйл бөгөөд нөгөө талаар хүний нөөцийн түүхчилсэн судалгаа болох тул нэмэлт өөрчлөлтийг тогтмол хийж, баяжуулж байна.

Тав. Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангаж, сургаж, чадваржуулах бодлого:

Энэ хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Төрийн албан хаагчийн материаллаг бааз, техник хэрэгслээр хангах төлөвлөгөөтэй байх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хуулийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дүүргийн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлж байх

Гүйцэтгэлийн үр дүнг үнэлдэг тогтолцоог бүрдүүлж нэмэгдэл хөлс, урамшуулал олгож байх журам баталж хэрэгжүүлэх

Цалин хөлс, урамшууллын системийг өрсөлдөх чадвартай болгох

Ажиллагсдын дадлага, чадварын судалгаанд үндэслэн сул талыг харж, алдааг засах, давуу талыг нь ашиглан албан тушаалын өсөлт, хөгжлийг нь тооцож төлөвлөх, тэдэнд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

Зургаа. Ажлын үнэлгээ ба шагнал урамшууллын бодлого:

Тухайн ажил, албан тушаалтныг үнэлэхдээ хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн үнэлгээг, гүйцэтгэлийн үнэлгээтэй хослуулан дүгнэнэ. Байгууллага бүр өөрийн онцлогт нийцлүүлэн үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан мөрдөх

Байгууллага бүр үнэлгээнд суурилсан эрх тэгш, ялгаваргүй, хөгжлийн, урамшууллын шаталсан болон хөндлөн, босоо шилжилтийн урамшууллын тогтолцоотой байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: Хөтөлбөрийг 2014-2018 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Улсын төсвийн хөрөнгө
- Орон нутгийн төсөв, нөөц сангийн хөрөнгө
- Бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх, дүгнэх ажлыг Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэс хариуцан удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь энэхүү хөтөлбөр болон бусад холбогдох хууль, тогтоомжид заагдаагүй асуудлыг дотоод журмандаа тусгаж хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Дүүргийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллага, нэгжтэй хамтран гүйцэтгэнэ.

Найм. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийн үр дүнг жил бүрийн 12 дугаар сард дүгнэж хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” хэрэгжсэнээр:

- Хүний нөөцийн менежментийн ур чадвар бэхжинэ.
- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хуваарилалтад ахиц өөрчлөлт гарч чадвартай боловсон хүчнээр хангагдана.
 - Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар сайжирна. Тэдний ажлын бүтээмж дээшилж, хүний нөөцийн хуваарилалт сайжирч, боловсон хүчин мэргэшсэн, тогтвортой болно.
 - Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо төлөвшиж, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө сайжирна.
 - Төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэж, хүний нөөцийн судалгаа боловсронгуй болно.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

**“Иргэний оролцоог дэмжих”
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээс ТОГТООХ нь:

1. “Иргэний оролцоог дэмжих” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн үр дүнг жил бүрийн 3 дугаар улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 сарын
28-ны өдрийн 65 дугаар тогтоолын хавсралт



“Иргэний оролцоог дэмжих” хөтөлбөр

Нэг. Нийтлэг үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хууль, түүний үзэл баримтлал, Төсвийн тухай хуульд тусгагдсан үзэл санааг бодит ажил болгон Ерөнхийлөгчийн санаачлагаар баталсан “Шууд ардчилал-Иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг”-ийн үндсэн санааг дэмжин орон нутгийн эрх мэдлийг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлж шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлэх замаар төрийн үйл хэрэгт оролцох эрхээ эдлэх нөхцлийг нь бүрдүүлж, төсвийн менежментэд шууд ардчиллын хэлбэрийг баталгаажуулсан нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий бодлогын шинэлэг арга хэлбэрийг төлөвшүүлэн хэвшүүлнэ.

Эрх зүйн орчин: Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 176 дугаар зарлигаар батлагдсан бодлогын баримт бичиг, Монгол Улсын ерөнхийлөгчийн 2013 оны 01 тоот зарлиг, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2009 оны 20 тоот захирамж, Засгийн газрын 2012 оны 17 тоот тогтоолоор батлагдсан “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам” зэрэг бодлогын баримт бичиг зэрэг болно.

Иргэний оролцоог дэмжих нийгмийн хэрэгцээ, шаардлага: Иргэд гэдэг нь өргөн цар хүрээтэй ойлголт бөгөөд нийгмийн олон тооны бүлгүүдийг агуулдаг гэсэн утгаараа хөтөлбөрийн зорилтот бүлгийг Олон нийт гэж макро утгаар авч үзэхийн зэрэгцээ бид залуучууд гэсэн өвөрмөц онцлог бүхий нийгмийн бүлгийг зорилтот бүлэг болгон авч үзлээ. 2000 оны хүн амын тооллогын дүнгээр Монгол улсын 5 хүн ам тутмын нэг нь 15-24 насны залуучууд, 2004 оны байдлаар нийт хүн амын 39.5 хувь нь 15-34 насны залуучууд эзлэж байна. Иргэний оролцоог дэмжин иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүн амын дийлэнх хувийг эзэлж буй залуучууд, ард нийт болон зорилтот бүлгийн ашиг сонирхол, нас биеийн онцлогт суурилсан арга хэмжээг бодит ажил болгосноор нийгмийн хөгжил дэвшил орон нутгаас эхлэх нийгмийн нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага бүрдлээ олох ач холбогтой тул үр дүнд суурилсан хөтөлбөр хэрэгжүүлэх үндсэн зорилгыг агуулж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт:

Энэхүү хөтөлбөрийн зорилго бол иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүд, нийгмийн бүхий л төлөөлөл шууд оролцоогоор орон

нутгийнхаа болон төрийн шийдвэр гаргах үйл явцад хамтран оролцох, хяналт тавих нөхцөл бололцоог бүрдүүлэх, төрийн байгууллагууд иргэдийн оролцооны соёлыг хүлээн зөвшөөрөх, хууль, эрх зүйн хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, аливаа шийдвэрийг төр нь иргэдийн санал дээр тулгуурлан хамтран хэлэлцэж гаргахад оршино. Иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүд болон нийгмийн бүхий л төлөөллөөс орон нутгийнхаа хэмжээнд тулгамдаж буй нийтийн эрх ашгийг хөндсөн нэн тэргүүний шийдэх шаардлагатай асуудлаар хамтран зөвшилцөх замаар шийдвэр гаргах явцад оролцож төсвийн хөрөнгө санхүү, хүн хүчний нөөцийг чиглүүлэх, гүйцэтгэлийн чанарыг хянах нөхцлийг бүрдүүлэх, төр, захиргааны байгууллага нь иргэдийнхээ оролцооны соёлыг хүлээн зөвшөөрөх Хууль, эрх зүйн хариуцлагын тогтолцоог бүрдүүлж шийдвэр гаргах түвшинд хамтын ажиллагааг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

Иргэдийн оролцоо, хяналтын дүнд төрийн үйлчилгээний чанар, хүрэлцээ сайжирч, төсвийн зарцуулалт ил тод болсноор авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар хяналтыг сайжруулж үр дүнг үнэлж, дүгнэн тайлагнах бүхий л шатанд тэднийг шууд болон шууд бус хэлбэрээр оролцуулах бололцоогоор хангаж хэвшүүлснээр иргэд, төрийн байгууллагын ажлын уялдаа сайжирч иргэдийн эрүүл, аюулгүй, тохилог орчинд амьдрах Үндсэн хуулиар олгогдсон эрх хангагдана. Энэхүү зорилгод хүрэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Хөтөлбөрийн зорилтот бүлэг нь дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй иргэд олон нийт, дүүргийн залуучууд байна. Үүнд:

Зорилт - Нэг: Нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг иргэдийн оролцоотойгоор шийддэг механизмыг хэрэгжүүлэн төр, захиргааны байгууллагын шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусган, гарсан шийдвэрийг нийтэд тогтсон зарчмын дагуу мэдээллэх ажлыг “Иргэний танхим”-аар дамжуулан хэрэгжүүлж үйл ажиллагааг нь тогтворжуулан иргэдийг үр нөлөөтэй, хялбар, чирэгдэлгүй оролцох боломжоор хангах. Иргэний оролцооны E-Онлайн нөхцлийг бүрдүүлэх.

Зорилт - Хоёр: Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах. Иргэдийн оролцооны суурь нөхцөл болох мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах. /Дүүргийн ИТХ, Засаг даргын Тамгын газрын хэмжээнд E-Office орчинг бүрдүүлэх/

Зорилт - Гурав: Чадавхи бүрдүүлэх: Иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудыг “Иргэний оролцоог дэмжих” чиглэлээр чадавхижуулах

Зорилт - Дөрөв: Иргэдийн оролцоог бодитоор нэмэгдүүлэхэд чиглэсэн багц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,

Хөтөлбөрийн удирдлагыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төслийн удирдлагын ISO 125000 стандартын дагуу төлөвлөн хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор:

1. Хөтөлбөрийн удирдлагын хороо
2. Хөтөлбөрийн ажлын хэсэг

3. Хөтөлбөрийн хараат бус шинжээчдийн хэсгийг байгуулна.

Хөтөлбөрийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг:

Бүрэлдэхүүн - Дүүргийн түвшний бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид, судлаачид, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөл:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлагаар хангах, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, хэрэгжилтийг мэдээлэх, сурталчлах, үр дүнг тайлагнахад хяналт тавих
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд дотоодын болон хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх
- Хөтөлбөрийг холбогдох төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулж, хэрэгжилтийг хангах
- Шаардагдах санхүүжилтийн төсөв, төлөвлөгөөг гарган хөрөнгө босгох ажлыг зохион байгуулах
- Шаардлагатай үйл ажиллагааг төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах

Хөтөлбөрийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг:

Бүрэлдэхүүн - Төслийн зорилтот бүлэг бүрээр ажлын хэсэг байгуулагдах бөгөөд хөтөлбөрийн чиглэл салбараар мэргэшсэн ТББ байна.

- Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааны өдөр тутмын хэрэгжилтийг хангах,
- Хөтөлбөрийн төлөвлөлтийг хариуцан, нарийвчилсан төлөвлөгөө гаргаж батлуулах, эргэн тайлагнах ажлыг хариуцан зохион байгуулах
- Шаардлагатай зарим ажил ТББ болон иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажил, үйлчилгээ, бараа худалдан авах асуудлыг шийдвэрлэх,
- Хөтөлбөрийн гүйцэтгэлд дотоодын хяналт шинжилгээ хийх, гарсан үр дүнгийн дагуу авах арга хэмжээг төлөвлөх

Хөтөлбөрийн хараат бус шинжээчдийн хэсгийн чиг үүрэг:

- Хөтөлбөрийн стратегийн төлөвлөлтийн бодлого боловсруулах, шаардлагатай судалгаа шинжилгээ хийхэд мэргэжлийн зөвлөгөө үзүүлэх
 - Хөтөлбөрийн орчин, нөлөөлөх хүчин зүйлсийн дүн шинжилгээ, аналитик загвар боловсруулах
 - Хэрэгжүүлэх үйл ажиллагааны сонголт, хүрэх үр дүн болон нийгмийн үр өгөөжид хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх
- Дөрөв. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн дэвшүүлсэн зорилго, зорилтыг биелүүлэх үүднээс дараах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Судалгаанд суурилсан шийдэл: Дүүргийн хэмжээнд Шууд ардчилал, иргэний оролцоог үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг судалж зорилтот бүлгүүдийг тодорхойлж, шийдлийн хувилбарыг боловсруулах,
2. Технологи, инновацид суурилсан шийдэл: Иргэдийн E-Онлайн оролцоог нэмэгдүүлэх техник технологийн орчин нөхцлийг хангах, мэдээллийн ил тод байдлыг хангах E-office орчин бий болгох,
3. Чадавхижуулах сургалт: Шууд ардчилал, иргэний оролцооны чиглэлээр ажиллах хүний нөөц бүрдүүлэх сургалтуудыг зохион байгуулах
4. Сонирхолд суурилсан иргэдийн шууд оролцоо: дүүргийн иргэдийг нийгмийн амьдралын салбар бүрээр, тэдний ашиг сонирхолыг хөндөж буй чиглэл бүрээр бүлэглэх замаар оролцоог бодитойгоор нэмэгдүүлж хүрэх үр дүнг сайжруулах.
5. Иргэдийн бололцоонд суурилсан оролцоо: Иргэдийн цаг зав, боломж бололцоонд тулгуурлах замаар урлаг соёлын арга хэмжээг сонирхолтой хэлбэрээр өрнүүлэн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,

Хөтөлбөрийн хүрээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шууд ардчиллыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Иргэний танхим”-аар дамжуулан зохион байгуулна.

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн дараах үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ.

Үүнд:

4.1 Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор улсын төсвөөс хуваарилагдах хөрөнгийг иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах нөхцлийг бүрдүүлж төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах боломжоор хангана.

4.2 Иргэдийг мэдээ, мэдээллээр хангана.

4.3 Иргэдээс бүхий л салбарт өргөнөөр оролцох нөхцөл бүрдэнэ.

Хөтөлбөрийн эхний шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцах нэгж, албан тушаалтан
1	Хөтөлбөрийн төслийг боловсруулан сонирхогч талуудыг хэлэлцүүлэгт оролцуулах		Хөтөлбөрийн төсөл бэлэн болж иргэд хэлэлцүүлэгт хамрагдсан байх.	Дүүргийн ИТХ, Засаг даргын Тамгын газар
2	Хөтөлбөрийг батлуулан шийдвэр гаргуулах		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлогын шийдвэр гарсан байх.	Дүүргийн ИТХ, Засаг даргын Тамгын газар

3	Хөтөлбөрийн нэгжийг байгуулж зохион байгуулалтын асуудлыг шийдэх		Хөтөлбөрийн багийн бүтэц, зохион байгуулалт бэлэн болно	Хөтөлбөрийн удирдлагын хороо
4	<p>Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа:</p> <p>А. Нээлттэй хэлэлцүүлгүүд (ТВ, сонин, ОНМХ)</p> <p>Б. Нийгмийн сүлжээнд хөтөлбөрийн орон зайг бий болгох</p> <p>В. Сонирхогч талуудын дунд дэмжлэгийн бүлгүүд үүсгэх</p>	2014-2016 он	Олон нийт болон сонирхогч бүлгүүд хөтөлбөрийн талаар ойлголт мэдлэгтэй болж бүх түвшинд сонирхлын бүлгүүд үүснэ	Хөтөлбөрийн удирдлагын хороо, Ажлын хэсэг
5	<p>Судалгаанд суурилсан шийдэл:</p> <p>А. Шууд ардчилал, иргэний оролцоог үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг судалж зорилтот бүлгүүдийг тодорхойлон шийдлийн хувилбарыг боловсруулах</p> <p>Технологи, инновацид суурилсан шийдэл:</p> <p>А. Иргэдийн E-Онлайн оролцоог нэмэгдүүлэх техник технологийн орчин нөхцлийг хангах, мэдээллийн ил тод байдлыг хангах E-office орчин бий болгох</p> <p>Чадавхижуулах сургалт:</p> <p>А. Шууд ардчилал, иргэний оролцооны чиглэлээр ажиллах хүний</p>	2014-2016 он	<p>Асуудлыг дэвшүүлэх бус шийдвэрлэхэд чиглэсэн шийдлийн хувилбар бий болно.</p> <p>Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх техник технологийн орчин бий болно.</p> <p>Иргэдийн чадавхи</p>	Дүүргийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Хөтөлбөрийн удирдлагын хороо

	нөөцийг бүрдүүлж сургалтуудыг зохион байгуулах		сайжирна.	
7	<p>Сонирхолд суурилсан иргэдийн шууд оролцоо:</p> <p>А. Иргэдийг нийгмийн амьдралын салбар болон ашиг сонирхолыг хөндөж буй чиглэл бүрээр сегментлэн бүлэглэх замаар оролцоог бодитойгоор нэмэгдүүлж хүрэх үр дүнг сайжруулах.</p> <p>Иргэдийн бололцоонд суурилсан оролцоо:</p> <p>А. Иргэдийн цаг зав, боломж бололцоонд тулгуурлах замаар /өглөөний цай, явган аялал зэрэг/ урлаг, соёлын арга хэмжээг сонирхолтой хэлбэрээр зохион байгуулж иргэдийг өргөнөөр оролцуулах</p>	2014-2016 он	Иргэдийн оролцоог бодитойгоор нэмэгдүүлэх арга хөшүүргүүд тодорхой болно.	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөтөлбөрийн удирдлагын хороо
8	<p>Хөтөлбөрийн явц, үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ:</p> <p>А. Дотоод болон хөндлөнгийн хяналт шинжилгээ</p> <p>Б. Үр дүнгийн үнэлгээ</p>	2015-2016 он	Хөтөлбөрийн үйл явцыг хянаж, төлөвлөсөн үр дүнд хүрэх рациональ механизм бий болно.	Дүүргийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Хөтөлбөрийн удирдлагын хороо

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хамрах хүрээ:

Хэрэгжүүлэх хугацаа: 2014-2016 он

Хамрах хүрээ: Орон нутгийн төр, захиргааны байгууллага болон дүүргийн иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүд, нийгмийн бүхий л төлөөллийг хамруулна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт:

- Улсын болон орон нутгийн төсөв
- Үндэсний ба олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр
- Бусад эх үүсвэр

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хянах, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, тайлагнах:
Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нь:

Шинэчлэлийн хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцын хяналт-“Deming circle”-ийн шатлалаар хийнэ.



Хяналт – шинжилгээ¹-ний тусламжтайгаар үйл явц хэрхэн урагшилж дэвшиж, хөтөлбөрт дэвшүүлсэн зорилгодоо хүрч байгаа, хүний болон санхүүгийн нөөцийн ашиглалтад ямар ахиц гарч байгаа талаар удирдлага, гол оролцогчдыг мэдээллээр хангахын тулд тодорхой үзүүлэлтүүдийн тоо баримтыг системтэй цуглуулах ажиллагааг тогтмол явуулна. Хяналт-шинжилгээ нь байнга, тасралтгүй явагдаж байх дотоод үйл ажиллагаа тул Хяналт-шинжилгээний системийн хүрээнд багц үзүүлэлт бүхий шалгуур үзүүлэлт бүхий цогц тогтолцооны тусламжтайгаар: 1. Төлөвлөлт, 2. Хэрэгжилт, 3. Хяналт шинжилгээ, Үнэлгээ, 4. Дүн шинжилгээ, тайлан гэсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Үнэлгээ¹ гэдэг нь урьдаас төлөвлөсөн, одоо үргэлжилж байгаа, эсвэл хийж дууссан үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийн үнэ цэнэ, ач холбогдлыг аль болох системтэй, бодит байдлаар тодорхойлох үйл явц бөгөөд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх чухал ажлын нэг юм. Үнэлгээг хэрэгжилтийн явцын үнэлгээ /formative evaluation/, нэгтгэн дүгнэх үнэлгээ /summative evaluation/, урьдчилсан үнэлгээ /prospective evaluation/ гэсэн ангиллаар хийнэ. Хэрэгжилтийн явцын үнэлгээ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн үед хийгдэх бөгөөд хэрэгжилтийг сайжруулах бодлогын зөвлөмж гаргахад чиглэнэ. Хэрэгжилтийн явцын үнэлгээг дараах шалтгаанаас үүдэн мөн хийж болно. Тухайлбал, хууль тогтоомжийн шаардлагатай нийцүүлэх зорилгоор эсвэл томоохон үнэлгээ хийх санаачлагын улмаас хийх боломжтой. Нэгтгэн дүгнэх үнэлгээг хэрэгжилтийн төгсгөлд, түүний хүлээгдэж буй үр дүнгийн хэмжээг тодорхойлох зорилгоор хийнэ. Нэгтгэн дүгнэх үнэлгээ нь хөтөлбөрийн үнэлэмжийн тухай мэдээллийг гаргахад чиглэнэ.

Доорх шийдлийн хүрээнд үнэлгээний үр дүнг ашиглана. Үүнд:

- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд нөөц хуваарилах, шийдвэр гаргахад тус дэмжлэг үзүүлнэ.
- Асуудлын шалтгааныг дахин шинжлэн бодож үзэхэд тус болно.
- Шинэ тутам гарч ирж буй асуудлуудыг тодотгоход хэрэг болно.
- Боломжит болон хамгийн оновчтой хувилбарыг сонгох талаар шийдвэр гаргахад дэмжлэг болно.
- Асуудлын шалтгаан болон түүнийг хэрхэн шийдэх талаар зөвшилцөлд хүрэхэд хэрэг болно.

Хяналт-шинжилгээ ба үнэлгээний аль аль нь хэрэгжилтийг хэмжиж, үнэлдэг явц ба харилцан адилгүй аргаар, өөр өөр цаг хугацаанд хийгдэх цогцолборт арга хэмжээ хэмээн үзэж байгаа бөгөөд асуудлыг томъёолох, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх, Анализ, дүн шинжилгээ хийх, Шийдлийн хувилбарууд боловсруулах, сонголт хийх, Хэрэгжүүлэх гэсэн тойргоор хийгдэх ажил хэмээн үзэж байна.

Хүснэгт: Хяналт шинжилгээ, Үнэлгээг харьцуулах нь:

Хяналт - Шинжилгээ	Үнэлгээ
Тогтмол хийгдэж, үргэлжилж байдаг	- Үе үе хийгддэг, цаг хугацааны хязгаартай
Дотоод үйл ажиллагаа	- Дотоод, хөндлөнгийн, эсвэл хамтын оролцоот үйл ажиллагаа
Удирдлагын хариуцах чиг үүрэг	- Үнэлгээчид, ажилтнууд ба удирдлагатай хамт хүлээх хариуцлага
Хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахын тулд эргэх мэдээллийн холбоо тогтмол хийгдэнэ	- Тодорхой хугацаанд эргэх мэдээллийн холбоо хийгдэнэ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих
дүүргийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Засгийн Газрын 2014 оны 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 онд хэрэгжүүлэх “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийн биелэлт хэрэгжилтийн явц, хэрэгжилтийн үр дүнг жил бүрийн 3 дугаар улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба /Ц.Алтанцацарал/-д даалгасугай

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ





“Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих” дэд хөтөлбөр
/2014-2016 он/

Нэг. Нийтлэг үндэслэл

2007 онд Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль батлагдсан нь эрх зүйн орчин бүрдэж, өрхийн болон хувиараа бизнес эрхлэгчдийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх сонирхол идэвхжсэн. Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан 2011-2013 хүртэлх Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд хөтөлбөр, Нийслэл дүүргийн Засаг даргын 2012-2016 мөрийн хөтөлбөр 2014 оны нийгэм эдийн засгийн зорилт, шинэ мэдлэг бүтээгдэхүүн үйлчилгээ бүхий Инновацийн тогтолцоог дэмжих улмаар нэмүү өртөг шингэхүйц шинэ технологи, мэдлэгийг Жижиг дунд үйлдвэрийн салбарт бий болгон, судалгаан дээр үндэслэн үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэхэд жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгч нарын оролцоог нэмэгдүүлэн хөгжүүлэх шаардлагатай байгаа нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, зах зээлд өрсөлдөхүйц бараа бүтээгдэхүүн бий болгоход оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хууль эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, тэдэнд төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх:

3.1.2. Үйлдвэрийн кластерт ажлын байр бий болгосон жижиг, дунд үйлдвэрлэгчдэд зээл санхүүгийн дэмжлэгийг тэргүүн ээлжинд үзүүлэх:

3.1.3. Судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх, санхүү зээлийн уян хатан бодлогоор дэмжих, бусад эх үүсвэрүүдийн мэдээлэл өгч зуучлах:

3.1.4. Жижиг, дунд үйлдвэрлэлийг чадавхижуулах, хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлын байраар хангах, “Бизнес Инкубатор төв”-үүдээр дамжуулан сургаж бойжуулах, мэдээллээр хангаж зөвлөгөө өгөх:

3.1.5. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн боловсруулсан эдийн засгийн үр ашиг бүхий төслийг шалгаруулж, зээл олгоход дэмжлэг үзүүлэх:

3.1.6. Зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгох:

Дөрөв. Хөтөлбөрийн хугацаа

4.1. Хөтөлбөрийг 2014-2016 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Хууль эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, тэдэнд төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх, арга хэмжээ

5.1.1. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5.1-т заасан шаардлагыг хангасан, тухайн хуулийн 6.6-д заасны дагуу бүртгүүлсэн аж ахуй нэгж байгууллага, иргэнийг “Жижиг, дунд үйлдвэрлэгч мөн” гэж бүртгэн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

5.1.2. Дүүргийн жижиг, дунд үйлдвэр, бизнесийн орчны төлөв байдлыг тодорхойлон үнэлгээ өгч судалгаануудыг багцлан жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг салбар тус бүрээр тодорхойлох.

5.1.3. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хууль эрх зүйн, бизнесийн төсөл боловсруулах сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ном, товхимол, гарын авлага бэлтгэн гаргах.

5.1.4. Мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран жижиг, дунд үйлдвэрлэгчид, бичил бизнес эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, жижиг, дунд үйлдвэрийн маркетинг, менежментийг боловсронгуй болгох чиглэлээр төсөл бичих, боловсруулах аргачлалд сургаж заавар зөвлөгөө өгч мэдээллээр хангах.

5.2. Зээл, санхүүгийн дэмжлэгийг үйлдвэрийн кластерт ажлын байр бий болгосон жижиг, дунд үйлдвэрлэгчдэд тэргүүн ээлжинд үзүүлэх:

5.2.1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх хөшүүргийг бий болгох, бүртгэлтэй аж ахуй нэгж, иргэнд төрөөс дэмжлэг, авах бололцоог бүрдүүлэх.

5.2.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт кластер хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох.

5.2.3. Жижиг, дунд үйлдвэрлэлийн кластер байгуулах санаачилга, кластерт нэгдэх үйл ажиллагааг дэмжих, жижиг, дунд үйлдвэрийн кластерын талаар баримтлах стратегийг боловсруулах.

5.3. Судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх, санхүү зээлийн уян хатан бодлогоор дэмжих, бусад эх үүсвэрийн талаар мэдээлэл өгч зуучлах:

5.3.1. Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх.

5.3.2. Хөгжлийн инноваци төвийг байгуулснаар жижиг, дунд үйлдвэрт инноваци нэвтрүүлэх

5.3.3. Оюуны өмчийн үр ашигтай менежментийг нэвтрүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, нийгэм эдийн засагт гүйцэтгэж байгаа үүргийг тооцох аргачлалыг боловсруулах.

5.4. Жижиг, дунд үйлдвэрлэлийг чадавхижуулах, хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлын байраар хангах, “Бизнес Инкубатор төв”-үүдээр дамжуулан сургаж бойжуулах, мэдээллээр хангаж зөвлөгөө өгөх:

5.4.1. Жижиг, дунд үйлдвэрт зориулсан зөвлөх үйлчилгээг хөгжүүлж, бизнесээ эхлүүлэх, аж ахуй эрхлэх санаачилгыг идэвхижүүлэн, бойжигчдыг дэмжих

5.4.2. Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвүүдтэй хамтран мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог сайжруулах

5.4.3. Жил бүр “Бизнес Инкубатор төв”-өөр дамжуулан бойжигчоор чадавхижуулж өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.

5.5. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдээс боловсруулсан эдийн засгийн үр ашиг бүхий төслийг шалгаруулж, зээл олгоход дэмжлэг үзүүлэх:

5.5.1 Төсөл сонгон шалгаруулах зарчмаар өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамруулна.

5.5.2. Жижиг, дунд үйлдвэр, бичил бизнес эрхлэгчдийг урт хугацаатай хүүгийн хөнгөлөлттэй зээлд хамруулснаар ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

5.5.3. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах

5.5.4. Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээс /лизинг/-ээр олгох үйл ажиллагааг өргөтгөх

5.6. Зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээг бий болгох:

5.6.1. Дүүргийн нутаг дэвсгэрт “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны сүлжээ цэгийг ажлилуулсанаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах нэгдсэн сүлжээг бий болгох.

5.6.2. Үндэсний брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сурталчлах, туршлага солилцох зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах.

5.6.3. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуултанд цахим худалдааг өргөнөөр нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, төрийн байгууллагуудын бараа, бүтээгдэхүүн худалдан авах үйл ажиллагаанд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах, нийлүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүүргийн Засаг дарга хангуулж, жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, (Тэргүүлэгчид) хяналт тавина.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт, эх үүсвэр

7.1. Хөтөлбөр тусгагдсан арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын болон /орон нутгийн төсөв/
- Засгийн газрын бонд
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө
- Орон нутгийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгө
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгө
- Инновацийг дэмжих сангийн хөрөнгө
- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө
- Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл,

хөтөлбөрийн санхүүжилт

- Бусад эх үүсвэр

7.2. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага дор дурдсан ажлыг эрхэлнэ.

7.2.1. Хөтөлбөр хэрэгжүүлэгч, оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах:

7.2.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд салбар хоорондын зохицуулалтыг бий болгох:

7.2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоог хангах:

7.2.4. Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан бодлого, арга хэмжээний хүрээнд тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан батлагдсан хуваарийн дагуу зарцуулж тайлагнана.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

8.1. Дүүргийн “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн үр дүнд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих эрх зүйн таатай орчин бүрдэж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, шинэ ажлын байрны тоог нэмэгдүүлсэн, хадгалсан байдлаар хэмжигдэнэ.

Хөтөлбөрийн нийтлэг шалгуур үзүүлэлт:

- Жижиг, дунд үйлдвэрийн талаар шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, хөтөлбөр төлөвлөгөө журмын хэрэгжилтийн үр дүн сайжирсан байна.

- Үйлдвэрийн кластерыг дагаж бий болсон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна.

- Дэмжлэгт хамрагдсан болон шинээр бий болсон ажлын байрны тооны өсөлт, тэргүүлэх салбар бүрээр тодорхой гарч ажлын байрны тоо нэмэгдсэн байна.

- Бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна.

- Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг хэвшүүлж жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх хэрэглэгчдийн тоо өссөн байна.

- Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийн лизинг, зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан иргэн аж ахуй нэгжийн тоо өссөн байна.

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, борлуулалтын хэмжээ өссөн байна.

- Шинэ санаачлага, техник технологи, инновацийг дэмжсэнээр жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирч, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бүрдүүлсэн байна.

Ес. Хяналт – шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төр захиргааны төв байгууллага хагас жилд нэг удаа хяналт-шинжилгээ хийнэ.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг үндэслэн үнэлгээ хийх бөгөөд эцсийн шатны үр дүнгийн судалгаа, шинжилгээг хөндлөнгийн байгууллагын оролцоотойгоор шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

9.3. “ Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний заалт бүрээр улирал тутам гаргаж, үр дүнг хянан хэлэлцэж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төр захиргааны төв байгууллагад ирүүлснээр дэлгэрэнгүй тайланг хагас болон бүтэн жилээр гаргаж тухайн жилийн 7 дугаар сарын 20, дараа оны 01 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний Зөвлөлд хүргүүлж хэлэлцүүлнэ.

9.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй уялдуулан дэд зөвлөлийг урамшуулах, хариуцлага тооцох болон бусад зохион байгуулалтын арга хэмжээний талаар жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төр захиргааны төв байгууллага санал боловсруулж Үндэсний Зөвлөлд танилцуулж болно.

9.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ тайланг холбогдох байгууллагууд цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

┌ Дүүргийн 2014-2016 оны “Бүтээмжтэй
ажлын байр” хөтөлбөр батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Бүтээмжтэй ажлын байр” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА  Д. БАТ-ЭРДЭНЭ



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 сарын
28-ны өдрийн 67 дугаар тогтоолын хавсралт



Бүтээмжтэй ажлын байр хөтөлбөр

Нэг. Үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангах, тэдний цалин хөлс амьдрал ахуйд нь хүрэлцээтэй болгох гэсэн зорилтын хүрээнд цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлнэ” гэж заасан.

Дээрх зорилтын хүрээнд Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2011 оны 03 дугаар захирамж, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2013-2014 оны улсын хэлэлцээр, Хөдөлмөрийн бүтээмжийн талаарх бодлого, үйл ажиллагаанд нийгмийн түншлэгч талуудын оролцоог тодорхой болгож, үндэсний болон салбар, орон нутаг, аж ахуйн нэгж байгууллагын түвшинд “Бүтээмжийн хөдөлгөөн”-ийг өрнүүлж, хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр талууд хамтран ажиллахаар тусгагдсан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2012-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, 2014 оны нийгэм эдийн зорилтын хэрэгжилтэнд тусгагдсан нь хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Зорилго

Дүүргийн Аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдэд хөдөлмөрийн бүтээмжийн талаарх ойлголтыг бий болгох сэдэл төрүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлж, санаачлагыг дэмжих.

Гурав. Зорилтууд

Зорилт - 1 Хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх

Энэ зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Хөдөлмөрийн бүтээмжийн талаар ойлголт бий болгох, сургалт сурталчилгаа хийх сурталчлах

3.1. Бүтээмжтэй ажлын байрны тухай, хөдөлмөрийн бүтээмжтэй холбоотой гарын авлага боловсруулж, нийтийн хүртээл болгох

Зорилт - 2 Хөдөлмөрийн бүтээмжийн үр дүнг үнэлэх, Аж ахуй нэгж байгууллагыг урамшуулан, туршлагыг сурталчлах

Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.2.1. Аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн үр бүтээлтэй ажилласан чиглэл бүрээс 1-2 /боловсрол, эрүүл мэнд, хүнс барилга, жижиг дунд үйлдвэр/ аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгаруулж, тэргүүн туршлагыг сурталчилна.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хянах, үнэлэх үүргийг Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөнийг өрнүүлэх салбар хороо, Хөдөлмөрийн хэлтэс хариуцна.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэж батална.

4.3. Хөтөлбөрийн нэгдсэн төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын төлөөлөл хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.4. Аж ахуйн нэгж байгууллагууд дэргэдээ Бүтээмжийн салбар зөвлөл, бүлэг ажиллуулна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Энэхүү хөтөлбөрийг 2014-2016 онуудад хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дор дурьдсан эх үүсвэрүүдийг ашиглана.

6.1. Орон нутгийн төсөв

6.2. Аж ахуйн нэгж байгууллагын дэмжлэг

6.3. Олон улсын хандивлагч байгууллагын хандив

Долоо. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр үнэлнэ

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд бүх талын төлөөллийн оролцоо жигд байна.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	2014 оны 11 сар	2015 он	2016 он
1	Хөдөлмөрийн бүтээмжийн талаар хийгдсэн сургалт сурталчилгаа, хамрагдах хүний тоо	-	1000	1500
2	Хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан гарын авлага, тараах материалын тоо	-	3000	5000
3	Хөтөлбөрийн хүрээнд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо /чиглэл бүрээс/	-	5	7

Ес. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

9.1. Хөдөлмөрийн бүтээмжийн талаарх нийгмийн ойлголт нэмэгдсэн байна.

9.2. Аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх арга барилд суралцаж, хөдөлмөрийн бүтээмж тооцох аргачлалыг туршиж үр дүнд хүрсэн байна.

9.3. Хөдөлмөрийн бүтээмжтэй холбоотой гарын авлага нийтийн хүртээл болсон байна.

9.4. Хөдөлмөрийн бүтээмжийн үр дүнг үнэлэх, шагнал урамшууллын тогтолцоо боловсронгуй болсон байна.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” дүүргийн
дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган
ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” дүүргийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагыг татан оролцуулах, хамтын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагаагаа эрчимжүүлхийг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах” дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах” дүүргийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэн, үйл ажиллагаагаа эрчимжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Дүүргийн 2014-2015 оны өвөлжилтийн
бэлтгэл ажил, цаашид хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад өвөлжилтийг хэвийн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгийн болон дундын өмчлөлийн шугам сүлжээний засвар үйлчилгээнд тогтмол хяналт тавьж, байгууллага иргэдийг ус, дулаан, цахилгаан хангамжаар тасралтгүй хангаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

「 Дүүргийн 2014-2016 оны “Хамтдаа хөгжье”
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ





“Хамтдаа хөгжье” хөтөлбөр

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 145 дугаар заалтад “Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөр, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-ийн 6 дугаар зүйл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл хэлбэр, Дүүргийн нийгэм, эдийн засгийн 2014 оны зорилтын 2.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ажил идэвхитэй хайж буй иргэд болон ажил олоход хүндрэлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 40-өөс дээш насны иргэд, жижиг дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлэх, иргэдийг бүлгээр хоршиж ажиллахыг дэмжих, хамтдаа хийж бүтээх, хөгжих, сурч боловсрох, мэргэших зэрэг өнөөгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Дүүргийн нийгэм эдийн засгийн 2014 оны зорилт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа бусад хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах нь үндсэн нөхцөл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Ажил идэвхтэй хайж байгаа, ажил олоход хүндрэлтэй иргэд, жижиг дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байранд тогтвор сууршилтай ажиллах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулахад нь дэмжлэг үзүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хугацаа

Хөтөлбөрийг 2014-2016 онд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хамрах хүрээ:

- Тогтвортой суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа иргэд /6 сар хүртэл ажиллаж чадаагүй ажлаас гарсан иргэд
- Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл явуулаад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулж чадахгүй байгаа иргэд

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

- Ажилд зуучлагдан 6 сараас доош хугацаагаар ажил хөдөлмөр эрхэлсэн иргэдийн бүртгэл, тандалт судалгааг Хөдөлмөрийн хэлтэс, Хороодын ажлын албатай хамтран зохион байгуулна.
- Тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа иргэд /6 сар хүртэл ажиллаж чадаагүй ажлаас гарсан иргэдийн шалтгаан, нөхцөл/-д дүн шинжилгээ хийх
- Тэдний дутагдаж буй ур чадварыг сайжруулах, шаардлагатай сургалтанд хамруулах, мэргэжил эзэмшүүлэх, давтан сургахад сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах

Хүрэх үр дүн:

Тандалт судалгааг хагас жилд нэг удаа зорилтот иргэдийн 10%-аас доошгүй хувийг хамруулан, дүн шинжилгээ хийсэн байна.

1. Тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа иргэдэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн боловсрол олгох сургалт, түр болон давтан сургалтанд хамруулсан байна.
2. Ажил олгогч болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай жилд нэгээс доошгүй удаа /20 -аас доошгүй ажил олгогч/ уулзалт, хэлэлцүүлэг хийсэн байна.

Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулах иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

- Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарын бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулахад гарч буй бэрхшээлийн талаар уулзалт, хэлэлцүүлэг хийж тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөвлөмж арга зүйгээр хангах
- Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарын тухай нэгдсэн мэдээллийг веб сайтад байршуулах, мэдээллийн товхимол хийж дүүргийн хэрэглэгч /айл өрх, аж ахуйн нэгж байгууллага/ нарт хүргэх ажлыг зохион байгуулах
- Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах цэгийг шинээр бий болоход дүүргээс дэмжлэг үзүүлэх
- Бүтээгдэхүүнийг борлуулахад гадаад, дотоодын жуулчдыг татах үйл ажиллагаа зохион байгуулах
- Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр тухайн газруудад үзэсгэлэн худалдаа, өдөрлөг яармаг зохион байгуулах, түүнд оролцох оролцоог дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах үйл ажиллагааг дэмжих

Хүрэх үр дүн:

- Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулахад гарч буй бэрхшээлийн талаар уулзалт, хэлэлцүүлэг хороо бүрт 20 доошгүй хүнийг хамруулаж зөвлөмж арга зүйгээр хангасан байна.
- Үйлдвэрлэл эрхлэгч, үйлчилгээ үзүүлэгч нарын тухай нэгдсэн мэдээлэлийг веб сайтад байршуулан, дүүргийн хэрэглэгч нарыг 50-аас доошгүй хувьд хүргэсэн байна. Мэдээллийн сан 2 жил тутам баяжигдсан байна.
- Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах 2-оос доошгүй цэг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Гадаад, дотоодын жуулчдыг татах, бүтээгдэхүүнээ сурталчлах ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.
- Нийтийг хамарсан арга хэмжээний үеэр тухайн газруудад үзэсгэлэн худалдаа, өдөрлөг яармаг зохион байгуулж, бүтээгдэхүүн борлуулж сурталчлах үйл ажиллагаа улирал бүр хийгдсэн байна.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

"Хамтдаа хөгжье" хөтөлбөрийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг арга зүйгээр хангаж зохицуулах, хянаж, үнэлэх үүргийг

Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх , Хөдөлмөрийн хэлтэс хүлээнэ. Хороодын Засаг даргын ажлын алба, аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ.

Зургаа. “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийн хяналт, шинжилгээ

Хөдөлмөрийн хэлтэс жил бүр төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийн үр дүнг жил тутам үнэлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд иргэдийн болон хамтрагч бүх талын төлөөлөл жигд, идэвхтэй оролцоно. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар жилд нэг удаа тайлагнана.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- Улс, нийслэл, Орон нутгийн төсөв
- Дотоод, гадаадын төсөл хөтөлбөр
- Олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагын хандив, тусламж
- ТББ хандив
-

Найм. Хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлт
Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуураар гаргана.

№	Шалгуур үзүүлэлт	2014 оны 10 сарын байдлаар	2015 он	2016 он
1	Ажилд зуучлагдан 6 сараас доош хугацаагаар ажил хөдөлмөр эрхэлсэн иргэдийн бүртгэлийг судалгааг гаргаж тандалт хийх	үгүй	10% доошгүй	12% доошгүй
2	Ажил олгогчийн урамшуулалд хамрагдсан аж ахуй нэгжийн тоо	8	10	12
3	Үзэсгэлэн худалдаа, яармагт оролцсон жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо	2 удаа- 30	4 удаа-40	6 удаа-50

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

- Ажилд зуучлагдсан иргэдийн тогтвор суурьшилтай ажиллах тоо нэмэгдсэн байна.
- Жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн байна.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Дүүргийн 2014-2016 оны “Залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2014-2016 оны “Залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ



Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр

Нэг. Нийтлэг үндэслэл

Чингэлтэй дүүргийн нийт хүн амын 54672 буюу 35%-ийг 18-35 насны залуучууд эзэлж байна. Хүн амд залуучуудын эзлэх хувь нэмэгдэж, залуучуудын санал бодлыг сонсож, шийдвэр гаргах болон хөгжлийн үйл явцад тэдний идэвх санаачилга, дуу хоолой, оролцоог хангах, эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх, залуучуудын эерэг зан үйлийг төлөвшүүлэх, дүүргийн Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлага урган гарч байгаа нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго.

Залуучуудад амьдрах ухааны болон гэр бүлийн боловсрол олгох, эерэг зан үйлийг төлөвшүүлэх, хөгжихөд хамтран ажиллах, идэвх оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хугацаа

Хөтөлбөрт дүүргийн 15-35 насны залуучуудыг хамруулан, 2014-2016 онд хэрэгжүүлнэ

Дөрөв . Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

4.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд

4.1.1. Залуучуудад амьдрах ухаан, хөдөлмөрийн хүмүүжил олгох үйл ажиллагааг дэмжих

4.1.2. Хөдөлмөрийн зах зээлд судалгаа хийж 9, 12 дугаар анги төгсөж буй хүүхэд залуучуудыг ажил, мэргэжил сонгох талаар мэдээллээр хангах

4.1.3. Оюутан залуучуудад цагийн ажлын талаарх мэдээллийг түгээх

4.1.4. Залуучуудын сонирхлын бүлгүүдийг хөгжүүлэх, хөдөлмөрөө хоршин ажиллах санал санаачилгыг дэмжих

4.1.5. Хугацаат цэргийн албанаас халагдсан албан хаагчдыг дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, Төрийн бус байгууллагууд, ажил олгогч байгууллагуудтай хамтран ажлын байраар хангах, ажилд зуучлах үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах

Хүрэх үр дүн:

1. Амьдрах ухааны болон хөдөлмөрийн хүмүүжил олгох сургалтанд дүүргийн хэмжээнд улирал тутам 100 орчим залуусын төлөөллийг хамруулж, хөтөлбөр боловсруулж, хороодод хүргүүлсэн байна.

2. Мэргэжил сонгох, хөдөлмөрийн чиг баримжаа олгох чиглэлийн сургалтанд ЕБС төгсөж буй 9, 12 ангийн сурагчдын 90%-ийг хамруулна.
3. Хороодын иргэний танхимыг түшиглэн мэдээллийг түгээж, хороо тус бүрээс 10-15 залуусыг хамруулна.
4. Сонирхолын бүлгүүдээрээ нэгдэж хөдөлмөрөөрөө хоршин ажиллаж буй залуусын 1-2 бүлгийн санаачлагыг, хороод бүр жилдээ дэмжин ажиллана.
5. Хугацаат цэргийн албаа амжилттай хаасан 5-10 орчим албан хаагчдыг жил бүр сургалтанд хамрагдаж, ажлын байраар хангагдсан байна.

4.2. Залуучуудын эрүүл зан үйлийг дэмжих, төлөвшүүлэх зорилтын хүрээнд

4.2.1. Өсвөр үе, залуучуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд сайн дураараа хамрагдах дадлыг хэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

4.2.2. Залуучуудад жендэр, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөв хандлага, эрүүл ахуйн зөв дадал хэвшилд сургах, аливаа өвчнөөс сэргийлэх, эрүүл хооллох, эрүүл мэндээ хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг иргэний танхимуудаар дамжуулан зохион байгуулах

4.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын эрүүл мэндийн тусгай хэрэгцээг хангах зорилготой нийгэм, хамт олонд чиглэсэн нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг Төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах

4.2.4. Цэрэг татлагаар орж эрүүл мэндийн байдлаас чөлөөлөгдсөн залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтарч зохион байгуулах

Хүрэх үр дүн:

1. Хорооны өрхийн эрүүл мэндийн төвд халдварт өвчнийг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ хийх нөхцөл бүрдсэн байна. Халдварт ба халдварт бус өвчин илрүүлэх компани ажил жилд 2 удаа хийгдэж, залуучуудын 20%-иас доошгүйг хамруулна.
2. Жендэр, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, амьдралын зөв дадалд хэвшүүлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хуваарь ил тод зарлагдаж, улирал тутамд 200-300 орчим залуусыг хамруулсан үйл ажиллагааг хороодын залуучуудын салбар зөвлөлөөр дамжуулан хийгдэнэ.
3. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын хөгжүүлэх ажил улирал тутам зохион байгуулагдсан байна.
4. Цэрэг татлагаар орж эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн залуучуудыг харъяа хороодын Эрүүл мэндийн төвүүдэд мэдээллийг хүргүүлж, эмчлэх үйл ажиллагааг эхлүүлэн үр дүнг тооцох

4.3. Залуучуудын боловсрол, соёлыг дэмжих зорилтын хүрээнд

4.3.1. Үндэсний өв соёлыг хөгжүүлэх хөдөлгөөн өрнүүлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх талаар мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх

4.3.2. Залуучуудын авьяас чадварыг дэмжин, залуучууд, оюутны чуулган, спорт, урлагийн наадмыг зохион байгуулах, түүх, соёл, уламжлалт зан заншлаа хамгаалан хөгжүүлэхэд оролцох оролцоог дэмжих,

4.3.3. Хүйсийн тэгш байдал, гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагын талаар залуу гэр бүлд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах,

Хүрэх үр дүн.

1. Үндэсний өв соёлыг хөгжүүлэх, угийн бичиг хөтлөх сургалтуудыг хороодын иргэний танхимуудаар дамжуулан мэдээлэл түгээж, сар бүр хороодын иргэний танхимд 20 залуусыг хамруулан тогтмол зохион байгуулсан байна.
2. Залуучуудын чуулган, урлаг, спортын наадам дүүргийн залуучуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх уриатайгаар дүүргийн хэмжээнд жил бүр зохион байгуулагдсан байна.
3. Хороо бүрт улирал тутамд олон талт үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна.

4.4. Залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд

4.4.1. Байгаль орчныг хамгаалах ардын уламжлалт зан заншлыг залууст төлөвшүүлэх, экологийн боловсролын талаархи мэдээлэл, сурталчилгаа, “Ногоон Дүүрэг” хөтөлбөрийг дүүргийн “Ахмадын хороо”, өсвөр үе, залуучуудын сайн дурын байгууллагуудын оролцоотой зохион байгуулах.

4.4.2. Өсвөр үе, залуучуудыг эх оронч үзэл хандлагыг ухамсарлуулах, гэмт хэрэгт өртөх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, зөв соёлч иргэн болгох нөлөөллийн үйл ажиллагааг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон холбогдох төрийн байгууллагууд, Төрийн бус байгууллагуудтай хамтран хийх.

4.4.3. Монгол улсын Батлан хамгаалахын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 онуудад хамтран ажиллах санамж бичгийн хэрэгжилтийг дүүрэгт хангаж ажиллах

Хүрэх үр дүн:

1. Байгаль орчныг хамгаалах, ардын уламжлалт зан заншлыг залуучуудад төлөвшүүлэх ажлыг “Дүүргийн ахмадын хороо” болон бусад ТББ-тай хамтран жилд 2 удаа 200 орчим залуучуудын төлөөллийг хамруулан зохион байгуулсан байна.
2. Дүүргийн ГХУСАЗЗ, Цагдаагийн хэлтсүүд, ХГБХТ болон ТББ-тай хамтран эх оронч үзэл хандлагыг ухамсарлуулах, гэмт хэрэгт өртөх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, зөв соёлтой иргэн болгох нөлөөллийн ажил хороо бүрт улирал тутам 200 орчим өсвөр үе залуучуудын төлөөллийг хамруулсан байна. Жилд нэг удаа нийтийг хамарсан ажил зохион байгуулагдсан байна
3. Санамж бичгийн хэрэгжилт хангагдсан байна.

4.5. Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжилтэн, бүлэг, нэгдэл, сайн дурын байгууллагуудыг чадавхижуулах зорилтын хүрээнд

4.5.1. Дүүрэг, хорооны түвшинд ялангуяа орон нутгийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

4.5.2. Залуучуудын чиглэлээр хийгдэж буй зарим үйл ажиллагааг Төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх

4.5.3. Хороон дахь залуучуудын салбар зөвлөлийг удирдлага арга зүйгээр ханган идэвхжүүлэх орон тооны бус залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, дэмжин ажиллах

4.5.4. Хорооны хөгжлийн нийгмийн ажилтан, хүүхэд гэр бүл хөгжлийн төвийн нийгмийн ажилтнуудыг сургах, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Хүрэх үр дүн:

1. Орон нутгийг хөгжүүлэх сангаар хийх ажилд залуучуудын оролцоо нэмэгдсэн байна.
2. Залуучуудын чиглэлээр явуулж буй 2 оос доошгүй арга хэмжээг ТББ-гаар гэрээгээр гүйцэтгүүлэх
3. Дүүргийн залуучуудын зөвлөлийн үйл ажиллагаа эрчимжиж, улирал бүр залуучууд руу чиглэсэн ажлуудыг хийсэн байна.
4. Жилдээ 2-оос доошгүй удаа нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах сургалтанд хамруулж, 3-аас доошгүй нийгмийн ажилтныг мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.

5.1. "Залуучуудын хөгжлийг дэмжих" хөтөлбөрийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хянаж, үнэлэх үүргийг Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв хүлээнэ.

5.2. Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв нь дүүргийн дэргэд шинээр байгуулах залуучуудын орон тооны бус зөвлөл, хороодын залуучуудын салбар зөвлөлийг арга зүйгээр хангах замаар манлайлан оролцох.

5.3. Хөтөлбөрийг дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төвийн дэргэдэх Залуучуудын хөгжлийн төв, залуучуудын орон тооны бус зөвлөл, хороодын Засаг даргын ажлын алба, хороодын залуучуудын салбар зөвлөл, аж ахуйн нэгж байгууллагын залуучуудын төлөөлөл хэрэгжүүлнэ.

5.4. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн оюутан залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгоход чиглэгдсэн ажлыг зохион байгуулалттайгаар явуулахад Цэргийн штаб дэмжлэг үзүүлж оролцоно.

Зургаа: Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний арга зүйг нэвтрүүлэх

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хагас жил тутам үнэлнэ.

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд Залуусын төлөөлөл, хамтрагч бүх талын төлөөлөл оролцоо жигд, идэвхтэй оролцуулсан байхаар үнэлнэ.

Хөтөлбөрийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт.

№	Шалгуур үзүүлэлт	2014 оны 10 сар	2015 он	2016 он	Мэдээллийг гаргах байгууллага, мэдээллийн эх сурвалж
1	Үйл ажиллагаа нь тогтмолжсон залуучуудын зөвлөлийн тоо	3 хороо	13	19	Залуучуудын зөвлөл байгуулан үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа хорооны ажлын албанаас
2	Ажил идэвхтэй хайж буй залуучуудын тоо үүнээс ажилд орсон	491	550	600	Хөдөлмөрийн хэлтэс
3	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан залуучуудын тоо	587	1000	1500	ЭМТ, өрхийн эрүүл мэндийн төвд шинжилгээ өгсөн залуучуудын тоо,
4	Халдварт бус өвчнөөр урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан залуучуудын тоо	53270 давхардсан тоогоор	65000 давхардсан тоогоор	5000 давхардсан тоогоор	ЭМТ, өрхийн эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан залуучуудын тоо,
5	Иргэний танхимаар үйлчлүүлсэн залуучуудын тоо	Одоогоор мэдээлэл судалгаа гараагүй	Суурь тоо гарна	Нэмэгдсэн байна	Иргэний танхим бүртгэл
6	Дүүргийн гэмт хэрэгт өртсөн залуучуудын тоо	тусдаа нэгтгэл гардаггүй	Судалгаатай болно	бууруулах	Дүүргийн цагдаагийн 1,2 дугаар хэлтсийн гэмт хэргийн бүртгэлээс
7	Цэрэг татлагаар орж эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн залуучуудын эрүүлжилтийн хувь	15 хүн 5,74%	35%	50%	Өрхийн болон ЭМТ нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд орж эрүүлжсэн тоогоор

Долоо. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

- Залуучуудын талаар хийгдэж буй ажлын үр дүнг хянаж үнэлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ
- Дүүргийн хороо бүрт Залуучуудын зөвлөл байгуулагдсан байна
- Залуучуудын идэвх оролцоо нэмэгдэнэ

Найм. Хөтөлбөрийн санхүүжилт

- Орон нутгийн төсөв, нийслэл, улсын төсөв
- Гадаад, дотоодын төсөл хөтөлбөр
- Аж ахуй нэгж байгууллагын хандив



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Хүүхдийн хууль зүйн хорооны үйл
ажиллагааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрхийг хамгаалах үүрэг бүхий Хүүхдийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

“Халдвар өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн
хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, салбар хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах оролцоог нэмэгдүүлэх, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Халдварт өвчний тандалт судалгаа, мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох, Эрүүл аюулгүй байдлын индексийн түвшинг хороо тус бүрээр гаргаж, нутаг дэвсгэртээ эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн эрүүл мэндийн хичээлийн чанар, хүртээмжийг сайжруулах, халдварт өвчний гаралтанд нөлөөлж буй орчны нөлөөллийг бууруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, төрийн бус байгууллагатай идэвх санаачлагатай хамтран ажиллаж, энэ чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг хагас жил тутам тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

“Боловсрол-2016” дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Боловсрол-2016” дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн сайн туршлагыг дэмжин, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг жил бүрийн 4 дүгээр улиралд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

“Ахмадын амралт, сувилал”-ын газрын
үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Ахмадын амралт сувилал”-ын газрын үйл ажиллагааг эрчимжүүлж, хэрэгжилт үр дүнг жил бүр тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ